



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 8/239

Улаанбаатар хот

Газар чөлөөлөх чиг үүрэг бүхий
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.5, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс дүүргийн 10 дугаар хороонд байрлах Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо орчмын айл, өрхтэй хэлцэл хийж, газар чөлөөлөх арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Засаг даргын орлогч

Гишүүд

Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

Дүүргийн 10 дугаар хорооны Засаг дарга

Дүүргийн Газар зохион байгуулалтын албаны дарга

Дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга

Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвийн дарга

Нарийн бичгийн дарга

Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн дарга

2. Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, үр дүнг дүүргийн Засаг даргад тухай бүр танилцуулж, холбогдох арга хэмжээ авахыг ажлын хэсэг (З.Бямбажав)-т үүрэг болгосугай.

3. Дээрх ажлыг зохион байгуулахад шаардагдах төсвийг холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (О.Батмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

15010692